

## Кркагийн Ёс зүйн дүрэм

**Боловсруулсан:**  
Байгууллагын нэгж, хэсэг:  
Санхүүгийн Хэлтэс  
Хууль Зүйн Хэлтэс

*Овог, нэр:*  
Нежа Мухич  
Марьета Пирц  
Барбка Рус Крумбергер

*Гарын үсэг, огноо:*

**Баталсан:**  
Байгууллагын нэгж, хэсэг:  
Дүрэм журмын мөрдөлт хариуцсан ажилтан  
Хууль Зүйн Хэлтэс  
Хүний Нөөц

*Овог, нэр:*  
Давид Братож  
Борут Лекше  
Борис Дулар

*Гарын үсэг, огноо:*

### Баталсан:

Удирдах Зөвлөл:  
72/2018 тоот тогтоолын дагуу 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдөр КРКА, д.д. Ново место компанийн ээлжит хуралдаанаар батлав.

*Огноо:*

**Хүчин төгөлдөр болсон огноо: 2018 оны 5 дугаар сарын 1**

Өмнөх хэвлэлийн хяналт	
Хэвлэл	Оруулсан өөрчлөлт
Удирдах Зөвлөлийн Тогтоол № 72/2018	Кркагийн Ёс зүйн дүрмийг батласнаар Крка, товарна здравил, д. д., Ново местогийн 2009 оны 12 сарын 2-ны Ёс Зүйн дүрмийг орлоно.
Удирдах Зөвлөлийн Тогтоол № 259/2009	Крка, товарна здравил, д. д., Ново местогийн 2009 оны 12 сарын 2-ны Ёс Зүйн дүрэм

“ОЧКО” Орчуулгын төвд орчуулж, хянав.  
Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот,  
Чингэлтэй Дүүрэг, Барилгачдын талбай,  
Силвер Төв, 1 тоот  
Утас/факс: 976-11-315055, 99267755

Цагийн хуваарь:  
Даваа-Баасан 09:00-19:00  
Бямба-Ням 10:00-18:00



Кркагийн Ёс зүйн дүрэм

УРЬДЧИЛГАА ЗААЛТУУД

ЁС ЗҮЙН ҮНДСЭН ЗАРЧМУУД

Хүндэтгэл

Хамтын ажиллагаа

Онц үйлчилгээ

Менежментийн зарчимч байдал

КОМПАНИЙН ЁС ЗҮЙ

Залилан, Авлигыг хориглох

Ашиг сонирхлын зөрчил

Бүтээгдэхүүний сурталчилгаа

Нийлүүлэгчид болон Бизнесийн Түншүүд

Шударга өрсөлдөөн

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

ДҮРЭМ ЖУРМЫН МӨРДӨЛТ ХАРИУЦСАН АЖИЛТАН

ЗҮЙ БУС ҮЙЛДЛИЙГ МЭДЭГДЭХ

ЭЦСИЙН ЗААЛТУУД

УРЬДЧИЛГАА ЗААЛТУУД

Кркагийн Ёс Зүйн Дүрэм (цаашид “Дүрэм” гэх) нь Крка Ново место болон түүний охин компаниудын баримтлах ёс зүйн дүрэм, зарчим, бизнесийн сайн ажиллагаа, үйл ажиллагааны стандартууд бөгөөд Кркагийн бүх ажилтнууд заавал дагаж мөрдөнө. Энэхүү Дүрэм нь Кркагийн дотоод дүрэм журмын үндэслэл болно.

Кркагийн бүх ажилтнуудын мөрдөх үндсэн зарчим бол үнэнч шударга байдал, мэргэжлийн үйл ажиллагааны талаарх ёс суртахууны хамгийн дээд стандарт, зарчмын дагуу ажиллах бөгөөд эм

“ОЧКО” Орчуулгын төвд орчуулж, хянав.  
Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот,  
Чингэлтэй Дүүрэг, Барилгачдын талбай,  
Силвер Төв, 1 тоот  
Утас/факс: 976-11-315055, 99267755

Цагийн хуваарь:  
Даваа-Баасан 09:00-19:00  
Бямба-Ням 10:00-18:00



зүйн салбарт олон улсын байгууллагуудаас тавигддаг дүрэм журам, удирдамжууд болон Кркагийн дотоод журмуудыг мөрдлөг болгох юм.

Энэхүү Дүрмийг Кркагийн <http://www.krka.biz/sl> вебсайтнаас үзэж болно. Кркагийн бизнесийн түншүүд Кркатай хамтран ажиллахдаа энэхүү Дүрэмтэй танилцаж энэхүү Дүрмийг мөрдөхийг бид хүсдэг.

## ЁС ЗҮЙН ҮНДСЭН ЗАРЧМУУД

Кркагийн ёс зүйн үндсэн зарчмууд нь ажилтнуудын болон байгууллагын харилцаанд харилцан хүндэтгэл, хамтын ажиллагаа, удирдлагын зарчимч байдал байна.

Кркагийн ажилтнуудын хувьд бид үндсэн зарчмуудыг мөрдлөг болгосноор Кркагийн алсын харааг бодит байдал болгон, бизнесийн төлөвлөгөөт зорилтонд хүрч Кркагийн нэр хүндийг хамгаалан өөрсдийн үйл ажиллагаа явуулах нийгмийн өргөн хүрээний орчинг би болгоход хувь нэмэр болно гэдгийг ухамсарлаж байна.

### Хүндэтгэл

Манай ажлын суурь зарчим бол бүгдэд ижил боломж олгох, хууль ёсыг хүндэтгэх мөн бүх хүн, нийгмийн орчинтойгоо ёс зүйтэй харьцах явдал юм. Бид хүний эрхийг олон улсад танигдсан зарчим, удирдамжуудад тодорхойлсоноор хүндэтгэдэг. Бид өөрсдийн үйл ажиллагаа явуулдаг бүх орны хүний эрхтэй холбоотой хууль дүрэм, стандартуудын дагуу ажилладаг.

Бид хувь хүн бүрийг хүн талаас нь авч үзэн тэдний хувийн нууцлалыг хадгалдаг. Бид мөн үг хэлэх болон санаа бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дээдлэн бусадтай хүндэтгэлтэй харьцдаг. Бид өөрсдийн хамт олонтой ажил мэргэжил, албан тушаалаас нь үл хамааран нээлттэй харьцдаг. Шударга бус, хууль бус бүх төрлийн ажлуудыг үйлдэх нь хориотой.

Ажилтнуудтай ялгавартай харилцах нь хориотой. Ажилтнуудыг иргэншинл, яс үндэс, нийгмийн гарал, нас хүйс, арьс өнгө, эрүүл мэнд, хөдөлмөрийн чадвар алдалт, шашин шүтлэг, итгэл бишрэл, бэлгийн чиг хандлага, гэр бүлийн нөхцөл байдал, үйлдвэрчний эвлэлийн гишүүн байх, санхүүгийн байдал болон бусад хувийн нөхцөл байдлаас үл хамааран ижил тэгш харьцана.

Ажлын байран дээрх бүх төрлийн дарамт шахалт, зүй бус харьцаа хориотой. Бид шударга, нээлттэй, бүтээлч ажлын орчин нөхцлийг бүрдүүлдэг. Бид бусад ажилтнууд, ахлахууд болон гуравдагч этгээдүүдээс аливаа сэтгэл зүйн, бэлгийн болон бусад дарамт шахалт, зүй бус харьцаа байхгүй ажлын орчинг бий болгодог. Бид хэн нэгнийг үл хүндэтгэсэн ямар нэг зүй бус үйлдлийг хийхгүй байх ёстой. Мөн бид хэн нэгэн ажилтны гаргасан зүй бус үйлдлийг ахлагч болон байгууллагын удирдлагад даруй мэдэгдэх ёстой. Удирдах ажилтны гаргасан зүй бус үйлдлийг түүнийг шууд удирдах ажилтан эсвэл дарамт шахалтын асуудал хариуцсан этгээдэд даруй мэдэгдэх ёстой. Дарамт шахалтыг аль ч ажилтан холбогдох эрх бүхий этгээдэд мэдэгдэж болно. Дарамт шахалтын үед мөрдөх журам болон дарамт шахалтын асуудал хариуцсан этгээдүүдийн

“ОЧКО” Орчуулгын төвд орчуулж, хянав.  
Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот,  
Чингэлтэй Дүүрэг, Барилгачдын талбай,  
Силвер Төв, 1 тоот  
Утас/факс: 976-11-315055, 99267755

Цагийн хуваарь:  
Даваа-Баасан 09:00-19:00  
Бямба-Ням 10:00-18:00



жагсаалтыг Кркагийн дотоод вебсайт Krkanet дээр нийтлэнэ. (Дарамт шахалтын үед мөрдөх журам)

**Бид аюулгүй, эрүүл ажлын орчинг бүрдүүлдэг бөгөөд ажилтнуудыг эрүүл мэндийн эрсдэлтэй нөхцөл байдалд оруулдаггүй.** Бид мөн эрүүл мэндийн болон ослын эрсдэлийг бууруулж арилгах арга хэмжээнүүдийг тогтмол хэрэгжүүлдэг. Хүн бүр ажлын байран дээрх эрүүл мэнд, аюулгүй байдлын бүх дүрэм, дотоод журмуудыг мөрдөнө. Бид эрүүл, аюулгүй ажлын орчин бүрдүүлэхийг үндсэн зарчим болгосон тул ажилтнууд ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис болон бусад хориотой бодисыг хэрэглэхийг хориглодог. Кркагийн ажлын байранд тамхи татах нь хориотой. Бид ажлаа өөрсдийн болон бусдын амьдрал эрүүл мэндэд аюул учруулахгүй байхаар зохистойгоор гүйцэтгэх ёстой. Ажлын тоног төхөөрөмж, аюулгүй байдлын хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл зэргийг зориулалтын дагуу, ажил олгогчийн зааврын дагуу ашиглах ёстой ба ажиллагаатай доголдолгүй байлгана.

Ажлын байран дээрх эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаатай холбоотой сургалтанд тогтмол сууж ажлын байранд аливаа аюул, алдаа дутагдлыг ахлагчдаа мэдэгдэх нь ажилтан бүрийн үүрэг юм.

#### Хамтын ажиллагаа

Бид ажилладаг орчиндоо хувьцаа эзэмшигч, ажилтнууд, нийлүүлэгчид, харилцагчид, байгууллагууд, иргэний нийгэмлэгийн байгууллагууд, хувь хүмүүс зэрэг янз бүрийн этгээдүүдтэй хамтран ажилладаг. Бид Кркагийн үнэ цэнийг өсгөх харилцан хүндэтгэл, өөр өөр үзэл бодлуудыг хүндэтгэн үзэх дээр суурилсан хамтын ажиллагааг дэмжиж ажилладаг.

Анагаах, эм зүй болон мал эмнэлгийн салбаруудтай харилцах харилцааны хүрээнд бид өөрсдийн бүтээгдэхүүний талаар нэг талыг баримтлаагүй, мэргэжлийн мэдээлэл олгоход анхаардаг ба ингэснээр өвчтөн, харилцагчдад илүү их ашиг тус үзүүлэн эмнэлгийн үйлчилгээг сайжруулж мэдлэг, үр чадварыг солилцох нөхцөлийг бүрдүүлдэг. Үүний зэрэгцээ дотоод дүрэм, журам, ёс зүйн өндөр стандартыг хатуу баримтлан ажиллах ёстой.

**Олон нийтийг** Кркагийн бүтээгдэхүүн, чанар, аюулгүй байдал, үр дүнтэй холбоотой нэг талыг үл баримталсан мэдээллээр хангана. Бүтээгдэхүүнээ боловсруулах, үйлдвэрлэх, борлуулах, сурталчлахдаа эмнэлэг, клиник, их сургууль зэрэг эрүүл мэндийн байгууллага болон боловсролын байгууллага, хяналтын байгууллага, анагаах ухааны салбарын төрийн байгууллагуудтай бүх дүрэм журмын дагуу хамтран ажилладаг бөгөөд баримт бичгийн ил тод байдлыг эрхэмлэдэг.

Бид **компаний үйл ажиллагааг нэгд нэгэнгүй, ил тод байдлаар тайлагнах** болон хяналтын эрх бүхий байгууллагууд, хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид, хэвлэл мэдээллийн байгууллагууд, шинжээчид болон олон нийтийг бүрэн гүйцэт, шударга, зохистой мэдээллээр хангахыг эрхэм болгодог. Бүх тайлан, санхүүгийн болон бизнесийн мэдээллийг хууль дүрэм, олон улсын тайлагналын стандартуудын дагуу бэлтгэж нийтлэдэг. Бизнес болон тайлагналыг хийхдээ бид бидний амжилт бол нийгэмтэйгээ нягт холбоотой тул өөрсдийн харилцагч этгээдүүдтэй ашигтай байдлаар ажиллах ёстой гэсэн үзлийг ухамсарладаг.

*“ОЧКО” Орчуулгын төвд орчуулж, хянав.*  
*Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот ,*  
*Чингэлтэй Дүүрэг, Барилгачдын талбай,*  
*Силвер Төв, 1 тоот*  
*Утас/факс: 976-11-315055, 99267755*

*Цагийн хуваарь:*  
*Даваа-Баасан 09:00-19:00*  
*Бямба-Ням 10:00-18:00*



## Онц үйлчилгээ

Бид үр ашигтай, чанартай, аюулгүй бүтээгдэхүүн олгодог. Санал сэтгэгдлийг хүлээн авах замаар бүтээгдэхүүний үр ашиг, чанар, аюулгүй байдлыг боловсруулалтаас эхлээд ашиглалт хүртэлх бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн бүх үе шатанд хянадаг. Бид эмнэлгийн бүтээгдэхүүний сөрөг нөлөөний талаар тайлагнах болон мэдээлэл цуглуулах системийг бий болгосон ба ингэснээр даруй арга хэмжээ авах боломжтой болсон.

Бидний судалгаа, шинжилгээ хийх болон эрүүл мэндийн салбар, бизнесийн түншүүдтэй хамтран ажиллах замаар эм зүйн салбар дахь өөрсдийн мэдлэгийг нэмэгдүүлдэг бөгөөд ингэснээр чанартай эмийн бүтээгдэхүүнүүдийг гаргахад хувь нэмэр болдог. Бид өөрсдийн судалгаа шинжилгээг хөндлөнгийн, мэргэжлийн түвшинд гүйцэтгэн үр дүнг зохих ёсоор хадгалан тайлагнаж санал сэтгэгдлийг үргэлж бодолцдог.

Бид өвчтөн, хэрэглэгч, эрүүл мэндийн ажилтнууд, олон нийт, хяналтын байгууллагууд, бизнесийн түнш болон худалдан авагчдад өөрсдийн бүтээгдэхүүний талаарх бүрэн гүйцэт, шударга, түргэн шуурхай мэдээлэл олгохыг эрхэм болгодог.

Ажлын хүрээнд хүлээн авах бүх мэдээлэл нь компаний өмч болох ба Кркад ажиллахаа больсон ч гэсэн ажилтнууд тэдгээрийг хамгаалах үүрэг хүлээнэ. Компаний доторх нууц мэдээллийг задруулах болон хувьд ашиглах нь хориотой бөгөөд мэдээлэл задруулсан компани, ажилтны эсрэг ажлын, захиргааны, иргэний, гэмт хэргийн арга хэмжээ авч болно.

Ажилтнууд нууцлалын зэрэгтэй эсхүл мөн чанарын хувьд нууц гэж үзэх мэдээллийг хамгаалах ёстой ба зөвшөөрөлгүйгээр хувийн ашиг сонирхолын хүрээнд ашиглах болон компани дотор болон гадна аливаа гуравдагч этгээдэд задруулах ёсгүй. Энэ нь ялангуяа бизнесийн нууцлалтай мэдээлэл, техникийн өгөгдөл, арилжааны мэдээлэл болон компани, ажилтнууд, гуравдагч этгээдүүдийн талаарх мэдээллүүдийн хувьд зайлшгүй чухал байна. Ажилтнууд мэдээлэл хамгаалах, хадгалахтай холбоотой бүх дүрэм журмуудыг мөрдөх ёстой. Бизнесийн түншүүдийн болон гуравдагч талуудын нууц мэдээлэл, оюуны өмчийг сайтар хамгаалах ёстой. (Худалдааны нууцыг тодорхойлж хамгаалах журам)

Тодорхой мэдээлэл нь нууцлалтай эсэх нь эргэлзээтэй үед тухайн мэдээллийг өндөр нууцлалтай гэж авч үзэх ба мэдээллийн өмчлөгч эсвэл Хууль зүйн хэлтэстэй зөвлөлдөнө. Бид цэвэрхэн ширээ, шилэн дэлгэц бодлогыг эрхэмлэнэ. Хэрэв нууцлалтай мэдээллийг и-мэйлээр илгээж байгаа бол тухайн агууламжийг агуулж буй хавсралт нь зөвшөөрөлгүй нэвтрэх явдлаас хамгаалагдсан эсэхийг нягталж шалгах ёстой. Бид и-мэйлээр гинжин захиа, онигоо, болон бусад зохисгүй материалыг илгээдэггүй. Бид кибер довтолгоонд өртөхгүйн тулд и-мэйлээр ирсэн баталгаагүй холбоос болон үл мэдэгдэх эх үүсвэрээс ирсэн хавсралтыг нээж үзэхгүй. Кркагийн **Мэдээллийн Аюулгүй Байдлын Мэргэжилтэн** нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг удирдан зохион байгуулна. Ажилтнууд санал бодлоо болон энэ тал дээрх дутагдалтай байдлыг Мэдээллийн Аюулгүй Байдлын Мэргэжилтэнд хэлж болно. (Мэдээллийн технологийн зохистой хэрэглээний журам)

“ОЧКО” Орчуулгын төвд орчуулж, хянав.  
Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот,  
Чингэлтэй Дүүрэг, Барилгачдын талбай,  
Силвер Төв, 1 тоот  
Утас/факс: 976-11-315055, 99267755

Цагийн хуваарь:  
Даваа-Баасан 09:00-19:00  
Бямба-Ням 10:00-18:00





Аливаа хувийн мэдээлэлтэй болгоомжтой, ил тод, аюулгүй байдлаар, хувийн мэдээллийг хамгаалах холбогдох журмын дагуу харьцах ёстой. Хувийн мэдээллийг зөвхөн хуулийн шаардлага болон Кркагийн хууль ёсны эрх ашгийг хангах зорилгоор эсвэл тухайн хувь хүний зөвшөөрлөөр цуглуулж болох ба мэдээлэл олгогч нь зөвшөөрлөө хэзээ ч хамаагүй цуцлаж болно. Хэрэв та таны хувийн мэдээллийг хамгаалах эрх зөрчигдсэн гэж үзвэл өөрийн ахлагчдаа хандаж эсвэл **Мэдээлэл Хамгаалах Мэргэжилтэнд** хандан зөвлөгөө авч болно. Хувийн мэдээлэлтэй холбоотой аливаа зөрчлийг 24 цагийн дотор даруй Мэдээлэл Хамгаалах Мэргэжилтэнд мэдэгдэнэ ([dataprotection.officer@krka.biz](mailto:dataprotection.officer@krka.biz)). Охин компаниудын Мэдээлэл Хамгаалах Мэргэжилтнүүдтэй холбогдох мэдээлэл нь дотоод вебсайт дээр бий. (Хувийн мэдээлэл хамгаалах журам)

Бид компаний нэр хүндийг хамгаалдаг. Бүх ажилтнууд Кркагийн стратегийн хувьд ач холбогдолтой зорилтууд, түүний зорилго, алсын хараа, үнэт зүйлстэй танилцах ёстой. Үүнтэй холбоотойгоор ажилтнууд нь харилцан итгэлцэл, хүндэтгэл, байнгын суралцах явдал, үүрэг хариуцлага, үр ашигтай ажиллах соёлыг бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулах ёстой. Мэдээллийг (цугларал, урсгал сургалт г.м) дотоод хурал, ажилтнуудын уулзалт, веб хуудас, дотоодын сэтгүүл, цахим холбоогоор солилцдог.

Кркагийн компаний байран дээр үүсгэсэн бүх фото зураг, видео, дуу бичлэгүүдийг сурталчилгаа хийх эсвэл хувийн зорилгоор хэвлэх, дижитал байдлаар нийтлэх бол Олон нийттэй харилцах хэлтсээс зөвшөөрөл авна ([public.relations@krka.biz](mailto:public.relations@krka.biz)). Кркаг олон нийтийн өмнө төлөөлөх эрх бүхий этгээдүүд л зөвхөн компаний өмнөөс хэвлэл мэдээллийн байгууллагуудтай харилцаж болно.

Цахим харилцаа нь манай бизнесийн харилцааны салшгүй хэсэг бөгөөд үүнийг Кркагийн болон Кркагийн бүтээгдэхүүний нэр хүндийг бий болгох, Кркаг олонд таниулахад ашиглана. И-мэйлийг Кркагийн нэр хүндэд хохирол учруулахгүйгээр зохистойгоор хэрэглэх ёстой.

**Нийгмийн сүлжээ** нь нууц байдлыг олгодоггүй гэдгийг ойлгож байгаа тул бид нийгмийн сүлжээ ашиглахдаа Кркагийн үнэт зүйлсийг баримтлан өөрсдийн хувийн зарчмыг бэхжүүлдэг. Нийгмийн сүлжээнд харилцахдаа бид тухайн сувгаар өөрсдийн болон Кркагийн талаар түгээсэн мэдээлэл нь хугацаагүйгээр нийтлэгдсэн хэвээр байдаг ба ямар ч хүн үзэх боломжтой гэдгийг ухамсарлана. (Ажилтнуудын онлайн нийгмийн сүлжээ ашиглах журам)

**Компаний хөрөнгөтэй** болгоомжтой харьцаж тэднийг зориулалтын дагуу, зохих ёсоор, дотоод дүрэм журмын дагуу ашиглана. Бүх ажилтнууд компаний хөрөнгийг дүрмийн дагуу удирдан зохион байгуулж тэднийг алдагдах, хулгайлагдах, зөвшөөрөлгүй ашиглагдахаас сэргийлнэ. Компаний хөрөнгө нь компаний хэрэгцээнд зориулагдсан бөгөөд зөвхөн онцгой нөхцөл байдалд зөвшөөрсөн цар хүрээнд хувийн зорилгоор ашиглаж болно. (Тоног төхөөрөмжтэй харьцах үед хувийн хариуцлагыг тогтоох журам)

Бид өөрсдийн гүйцэтгэдэг ажлын мөн чанарын хүрээнд материал болон ёс суртахууны хохирол учруулах эсвэл Кркагийн бизнесийн ашиг сонирхол, нэр хүндэд хохирол учруулж болох аливаа үйлдлийг хийхгүй байх ёстой. Бид ажлаа гүйцэтгэхдээ компаний ерөнхий имижийг хамгаалан Кркагийн заавар, дүрэм, бизнесийн ёс зүйг үргэлж мөрдөнө.

“ОЧКО” Орчуулгын төвд орчуулж, хянав.  
Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот,  
Чингэлтэй Дүүрэг, Барилгачдын талбай,  
Силвер Төв, 1 тоот  
Утас/факс: 976-11-315055, 99267755

Цагийн хуваарь:  
Даваа-Баасан 09:00-19:00  
Бямба-Ням 10:00-18:00



## Менежментийн зарчимч байдал

Гүйцэтгэх менежерүүд өөрсдийн ажил үүргээ гүйцэтгэхдээ өөрсдийн хувийн зарчим болон Кркагийн бизнесийн үйл ажиллагааны үндсэн зарчмуудыг бодолцож үзнэ. Компаний удирдлага болон ахлах менежерүүд нь өөрсдийн ажил, удирдлагын загвараараа бусаддаа үлгэр дуурайлал үзүүлэх ба ажилтнууд болон бусад харилцагч этгээдүүд дүрэм журам болон ёс зүйн хэм хэмжээний дагуу ажиллаж болохуйц бизнесийн болон ажлын орчинг бүрдүүлэхэд чухал үүрэгтэй юм. Удирдлага болон ахлах менежерүүд нь ажилтнуудад тэдний эрх, үүрэг, хариуцлага болон бүх холбогдох дүрэм, компаний дотоод журмыг танилцуулан тэднийг Кркагийн зарчим, журам, үнэт зүйлсийн дагуу ажиллуулах үүрэгтэй. Компаний удирдлага болон бүх ахлах менежерүүд нь ажил үүргээ гүйцэтгэхдээ эзэмшигч, ажилтнууд, компаний хөрөнгөтэй хариуцлагатай хандаж ажиллана.

Крка нь харилцан итгэлцэл, хүндэтгэл, хамтын ажиллагаа, багийн ажиллагаа, үргэлж суралцах, хариуцлагатай, үр ашигтай ажиллах соёлыг бий болгохоор ажиллаж байна. Бидний мэдлэг, чадвар, инноваци, ажлын сайн зуршил, бүтээлч байдал нь биднийг түргэн шуурхай, уян хатан байхад тусладаг. Өөрчлөгдөж буй бизнесийн орчинд үйл ажиллагаа явуулж байгаагийн хувьд бид зах зээлийн эрэлтэд түргэн шуурхай хариу үзүүлж, ахиц дэвшлийг даган, ажлын өөр арга ажиллагааны шаардлагуудад зохицон, уян хатан шийдлүүдийг олж ажиллах ёстой. Кркагийн ажилтнууд сайн харилцааг хөхүүлэн дэмждэг. **Түншлэл, итгэлцэл** нь бүх ажилтнууд, түншүүдийн дунд хүндэтгэлтэй харилцаа үүсэх үндэс суурийг тавьдаг. Бид ажилтнуудыг **бүтээлч, үр ашигтай** байхыг дэмжсэн ажлын орчинг бүрдүүлэхийг зорьж байна. Мөн бид ажилтнуудыг үргэлж шинэ санаа эрэлхийлэх, шинэ санааны талаар ярилцах болон зөв санаа бол амьдрал дээр хэрэгжүүлэхийг уриалан дэмжиж байдаг. Бид ажлаа бүх чадвараа дайчлан, аль болох үр дүнтэй, түргэн шуурхай гүйцэтгэдэг.

## КОМПАНИЙ ЁС ЗҮЙ

### Залилан, Авлигыг хориглох

Бүх ажилтнуудын ажил үүргээ гүйцэтгэхдээ баримтлах үндсэн зарчим бол үндсэн ёс зүйн зарчмууд, энэхүү Дүрмийн заалтууд болон Кркагийн холбогдох бүх дүрэм, дотоод журмуудыг мөрдлөг болгон ажиллах юм. **Залилан, Авлигын чанартай үйлдлүүд нь хориотой.**

Залилан, Авлигыг тусгай дүрмээр зохицуулан сэргийлнэ. (Залилангаас сэргийлэх, илрүүлэх, шалгах журам)

Кркагийн бүх ажилтнууд ёс зүйтэй, мэргэжлийн түвшинд, дүрэм журмуудын дагуу ажиллана. Крка компанид дараахуудыг хэрэгжүүлдэг:

- Бид залилан, авлигаас сэргийлэх болон компаний дүрэм журмыг баримтлах дээр хатуу ханддаг. Энэ нь ажилтнууд болон бизнесийн түншүүдийн хувьд ёс зүйгүй, мэргэжлийн бус, хууль бус үйлдэл гаргахыг тэвчихгүй гэсэн үг юм.
- Бид Кркагийн бизнесийн боломж, компаний хөрөнгө болон мэдээллийг хувийн, санхүүгийн давуу талыг бий болгохын тулд ашигладаггүй

“ОЧКО” Орчуулгын төвд орчуулж, хянав.  
Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот,  
Чингэлтэй Дүүрэг, Барилгачдын талбай,  
Силвер Төв, 1 тоот  
Утас/факс: 976-11-315055, 99267755

Цагийн хуваарь:  
Даваа-Баасан 09:00-19:00  
Бямба-Ням 10:00-18:00



- Бид улсын байгууллага, төрийн албан тушаалтан, бизнесийн түншүүд болон аливаа бусад этгээдэд нөлөөлөх зорилгоор хэн нэгэнд бэлэг болон ямар нэг давуу талыг бий болгох амлалт өгдөггүй ба бидний ажилтай холбоотой шийдвэрт нөлөөлж болох бэлэг болон бусад давуу талыг авдаггүй
- Бид зөвхөн үнэ цэнэ багатай билэг тэмдэг болон сурталчилгааны чанартай бэлэг, бизнес, соёлын, спортын, боловсролын болон бусад арга хэмжээ, үүлзалт зэрэг уламжлалт, нийтлэг, компаний арга хэмжээний цайллага хүлээн авалтыг хааяа зөвшөөрдөг ба тухайн арга хэмжээний үндсэн зорилгоос хэтрэх ёсгүй
- Бид хууль бус бэлэг, амлалт, үнэ цэнэтэй бэлэг болон бусад давуу талыг авах явдлыг илэрхийлж болох аливаа нөхцөл байдлаас зайлсхийдэг бөгөөд бидний бизнесийн түншүүдээс тийм хариу үйлдэл ирж болох ноцтой эрсдэлтэй бизнесийн харилцаанд ордоггүй.

Бид **дотоод мэдээллийг** авч буй этгээдүүд нь нууцлалын зэрэглэл болон тухайн мэдээллийн ноцтой чанарын талаар мэдэж байгаа эсэхийг анхаарч ажилладаг. Бид компаний санхүүгийн хэрэглүүрийг худалдах тал дээрх хүчин төгөлдөр дотоод журамтай бөгөөд ийм мэдээлэлтэй харьцдаг ажилтнууд, гуравдагч этгээдүүдэд хяналтын тогтолцоог бий болгосон. Ингэснээр бид мэдээллийг буруу замаар ашиглах болон дотоод мэдээлэл ашиглан арилжаа хийх явдлаас сэргийлдэг. Дотоод мэдээлэлтэй харьцдаг бүх хүмүүст хугацаа заадаг бөгөөд тухайн хугацаанд тэдгээр хүмүүс нь компаний санхүүгийн хэрэглүүрийг арилжих эрхгүй байдаг.

#### **Ашиг сонирхлын зөрчил**

Хэн нэгэн хувь хүний хувийн ашиг сонирхол хэн нэгэн ажилтны нухацтайгаар, нэг талыг баримтлалгүйгээр шийдвэр гаргах, Кркагийн сонирхолд нийцэхүйц ажлыг гүйцэтгэх чадварт нөлөөлж байгаа эсвэл нөлөөлөх боломжтой тохиолдлыг ашиг сонирхолын зөрчил гэнэ. Энэ нь тухайн хүний санхүүгийн ашиг сонирхол, хувийн ашиг сонирхол, түүний гэр бүлийн ашиг сонирхол, түүнд хамааралтай өөр хүний ашиг сонирхол байж болно. Зөрчил нь хэн нэгний бизнесийн, шинжлэх ухааны, улс төрийн болон бусад холбооноос үүдсэн үр дагавар байж болно.

Үндсэн зарчим бол ажилтнуудын гаргасан шийдвэр нь Кркагийн ашиг сонирхолын төлөө байх ёстой бөгөөд бүх ажилтнууд Кркагийн ашиг сонирхол бус, хувийн ашиг сонирхолын үндсэн дээр шийдвэрийг гаргасан гэж үзэгдэж болох нөхцөлөөс зайлсхийх хэрэгтэй.

Хэрэв бидний хувийн болон бусад нөхцөл байдал бидний болон хамтран ажиллагчийн ажил, шийдвэрт нөлөөлөх тохиолдолтой учирвал даруй ахлагчдаа мэдэгдэх хэрэгтэй. Ямар ч ашиг сонирхолын зөрчлийг мэдэгдэх ёстой бөгөөд тухайн нөхцөл байдлын дор бизнесийн шийдвэр гаргахаас зайлсхийх ёстой.

Ашиг сонирхолын зөрчлийг дараах тохиолдлуудад байна гэж үзнэ:

- Ажилтан нь өрсөлдөх компани эсвэл Кркагийн бизнесийн түншийн давамгайлсан эзэн байх.
- Ажилтан нь өрсөлдөх компани болон Кркагийн бизнесийн түнш компаниудад удирдах болон ахлах зөвлөлийн гишүүнээр ажилладаг байх.

“ОЧКО” Орчуулгын төвд орчуулж, хянав.  
Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот,  
Чингэлтэй Дүүрэг, Барилгачдын талбай,  
Силвер Төв, 1 тоот  
Утас/факс: 976-11-315055, 99267755

Цагийн хуваарь:  
Даваа-Баасан 09:00-19:00  
Бямба-Ням 10:00-18:00





- Ажилтан нь өрсөлдөх компани болон Кркагийн бизнесийн түнш компанид гэрээгээр болон бусад үндэслэлээр (төлбөртэйгөөр эсвэл үнэгүй) ажил гүйцэтгэдэг эсвэл үйлчилгээ үзүүлдэг байх.
- Ажилтан нь ажлын талаар болон ойрын гэр бүлийн гишүүдэд ашигтай байх шийдвэр гаргах

Ашиг сонирхолын зөрчлийн талаар эргэлзээ байвал өөрийн ахлагч, Хууль зүйн хэлтэс эсвэл Эрсэдлийн Удирдлага, Компаний Дүрмийн Мөрдлөгтэй зөвлөлднө үү.

Кркад ажиллах хугацаандаа, Кркагийн бичгээр үйлдсэн зөвшөөрөлгүйгээр өөрсдийн өмнөөс эсвэл аль нэг бусад талын өмнөөс Кркагийн гүйцэтгэсэн үйл ажиллагаатай ижил, Кркагийн өрсөлдөөн гэж үзэгдэх эсвэл өрсөлдөөн байх ямар нэг ажлыг гүйцэтгэх болон гэрээ хэлэлцээр байгуулж болохгүй.

### Бүтээгдэхүүний Сурталчилгаа

Эм зүйн салбар болон анагаах ухааны салбарын хоорондын харилцаа нь ёс зүйн хатуу стандарт, дүрэм журам, зааварт захирагддаг. **Кркагийн эм болон бусад бүтээгдэхүүнүүдийн сурталчилгаа** нь сурталчилгааны дүрмийн дагуу, эм болон бусад бүтээгдэхүүний аюулгүй хэрэглээг дэмжих байдлаар хийгддэг. Эмийг мөн чанарыг нь төвийлгөлгүйгээр, нэг талыг үл баримтлах зарчмаар таниулдаг. Үзэгчийн бүтнээр хүлээн авах сурталчилгааны бүх элемент болон хэсгүүд нь тухайн бүтээгдэхүүний зөвшөөрөгдсөн шинж чанарын хураангуйн дагуу байна. Бүтээгдэхүүний бүх шинж чанаруудыг тэнцвэртэй, ташаа бус байдлаар илэрхийлнэ. Маркетингийн төлөөлөгчид нь ажлаа хууль дүрмийн дагуу гүйцэтгэх ба бүтээгдэхүүн сурталчлахад зохих байдлаар бэлтгэгдсэн байна. (Кркагийн сурталчилгааны журам)

Бид **хурал, үүлзалт, мэргэжлийн арга хэмжээнүүдэд** оролцон өөрсдийн бүтээгдэхүүн, боловсруулах үйлдвэрүүдийг таниулах, үзүүлэх арга хэмжээ зохион байгуулж Кркагийн бүтээгдэхүүнд мэргэжлийн мэдээлэл олгох, сүүлийн үеийн нээлтийг таниулах, Крка нь олон нийтийн найдвартай түнш болохыг харуулах сургалт, арга хэмжээнүүдийг явуулдаг.

Бид анагаах ухааны мэрэгжилтнүүдийн мэдлэгийг сайжруулж эрүүл мэнд, өвчнөөс сэргийлэх арга хэмжээ, өвчний шинж тэмдэг, эмчлэх аргуудын талаар ерөнхий, үнэн зөв мэдээлэл олгох **шинжлэх ухаан, анагаах ухаан, эм зүйн судалгаа** болон боловсролын хөтөлбөрүүдийг дэмжиж ажилладаг.

Эрүүл мэндийн мэргэжилтнүүд, байгууллагуудад **хандив** болон бусад санхүүгийн, санхүүгийн бүс хөрөнгүүдийг олгох замаар сүүлийн үеийн анагаахын мэдлэг авч анагаах ухааны тогтолцоо, судалгааг дэмждэг. Эдгээрийг баримттайгаар, ил байдлаар, эрүүл мэндийн мэргэжилтнүүд, ажилчид, байгууллагуудын манай бүтээгдэхүүнийг жороор олгох, санал болгох, түгээх, борлуулах, худалдан авах ажилд нөлөөлөхгүй байх байдлаар хэрэгжүүлдэг.

Эрүүл мэндийн мэргэжилтнүүд, байгууллагууд, нийгэмлэг, холбоодод олгох бүх санхүүгийн, санхүүгийн бүх хөрөнгүүд нь мэргэжлийн хурал үүлзалт, лекц зэрэгт оролцоулах зорилготой бөгөөд Кркагийн вебсайт дээр 2018 оны 6 сарын 30-аас хойш жил бүр тавигдах тул ид тод юм.

“ОЧКО” Орчуулгын төвд орчуулж, хянав.  
Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот,  
Чингэлтэй Дүүрэг, Барилгачдын талбай,  
Силвер Төв, 1 тоот  
Утас/факс: 976-11-315055, 99267755

Цагийн хуваарь:  
Даваа-Баасан 09:00-19:00  
Бямба-Ням 10:00-18:00



## Нийлүүлэгч, Бизнесийн Түншүүд

Бид өөрсдийн харилцагч, нийлүүлэгч болон бизнесийн бусад түншүүдээ тогтмол шалган тэдэнтэй үүсгэх бизнесийн харилцаатай холбоотой эрсдэлүүдийг үр ашигтай байдлаар хянан удирддаг. Ингэснээр бид Кркагийн нэр хүндэд учирч болох аюул болон бизнесийн хохирлоос урьдчилан сэргийлдэг.

Бид нийлүүлэгчид, бизнесийн түншүүдээсээ дараахыг хүснэ:

- Хүний эрхийг дээдлэн хувь хүнийг хүндэтгэсэн, тэдний нууцлалыг хамгаалсан ажлын орчинг олгох
- Бүх төрлийн хууль бус ажлыг хүлээн авахгүй байх
- Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын систем, ашиг сонирхолын зөрчлийг илрүүлэх систем бий болгосон байх ба Кркад шууд, шууд бусаар нөлөөлөхүйц ашиг сонирхолын зөрчил илэрвэл бидэнд даруй мэдэгдэх
- Авлигын эсрэг болон өрсөлдөөний хуулийн дагуу ажиллан залилан, ёс бус үйлдэлтэй холбоотой эрсдэлүүдийг хянан удирдах ёстой.

## Шударга өрсөлдөөн

Бид өрсөлдөөнийг хамгаалах тухай хууль тогтоомжуудыг хүндэтгэн ямар нэг байдлаар өрсөлдөөнийг зайлуулах, хязгаарлах, нөлөөлөх үйлдэл гаргахгүй.

Бид бизнесийн ач холбогдол бүхий мэдээллийг өрсөлдөгчиддөө задруулахгүй. Бид өрсөлдөгч бүтээгдэхүүн, бүтээгдэхүүний хязгаарлал, борлуулалт, техникийн хөгжүүлэлт, хөрөнгө оруулалт, борлуулалтын газар нутаг, худалдааны зах зээлийн хэсгүүд, өсөлтийн стратеги, шинэ бүтээгдэхүүн, хэрэглэгч, борлуулалтын ерөнхий нөхцөлүүд зэрэгтэй холбоотойгоор бусад компаниудтай хуйвалдсан үйл ажиллагаа явуулдаггүй.

Хэрэв бид зах зээлийг давамгайлсан нөхцөлд байвал тухайн нөхцөл байдлыг ашиглан шударга бус худалдан авалтын эсвэл борлуулалтын үнэ болон бусад шударга бус худалдааны нөхцөлийг шууд, шууд бусаар тулгах ажиллагаа явуулахгүй, хэрэглэгчдийг хохироох бүтээгдэхүүний хязгаарлалт, зах зээлийн болон техникийн хөгжүүлэлт хийхгүй, бусад худалдааны талуудтай ижил гүйлгээнд ижил бус нөхцөл шахаж өрсөлдөөний сул тал учруулах явдал гаргахгүй, мөн чанар болон арилжааны хэрэгцээний хувьд гэрээний зүйлтэй холбоогүй нэмэлт үүргийг бусад талуудад тулгах гэрээ байгуулахгүй.

## НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Бид өөрсдийн бизнесийн амжилт нь өргөн хүрээг хамарсан нийгмийн бүлгүүдийн амжилттай холбоотой болохыг ухамсарладаг.

Бид өөрсдийн амьдардаг орчинд өөр өөр арга хэмжээг дэмжих, хүмүүнлэгийн үйл ажиллагаанд оролцох, шинжлэх ухаан, боловсрол, урлаг соёлын салбарууд дахь шинэ нээлт ололтуудыг дэмжсэн үйл ажиллагаануудад оролцох замаар нийгмийн үүргээ биелүүлдэг ба ингэснээр

“ОЧКО” Орчуулгын төвд орчуулж, хянав.  
Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот,  
Чингэлтэй Дүүрэг, Барилгачдын талбай,  
Силвер Төв, 1 тоот  
Утас/факс: 976-11-315055, 99267755

Цагийн хуваарь:  
Даваа-Баасан 09:00-19:00  
Бямба-Ням 10:00-18:00



байгаль орчноо хамгаалдаг. Нийгмийн хөгжил дэвшил, олон нийтийн амьдралын чанар, багачууд, залуучуудтай ажиллахад анхаарсан болон Кркагийн “Эрүүл амьдрахуй” гэсэн эрхэм зорилготой нийцсэн бүлэг, хувь хүн, урт хугацааны төслүүдийг чухалчлан үздэг.

Өөрсдийн эрхэм зорилгын хүрээнд Крка нь мөн засвар, шинэчлэлийн ажлуудыг санхүүжүүлэн янз бүрийн бүхий байгууллага, нийгэмлэгүүдийг орчин үеийн тоног төхөөрөмжөөр ханган илүү чанартай үйл ажиллагаа явуулах боломжийг олгодог. Бид орон нутагт болон хилийн чанад дахь соёлын төслүүдэд дэмжлэг үзүүлдэг.

Бид байгаль орчноо арчлан хамгаалж байгаль орчны тухай хууль тогтоомжуудыг хүндэтгэн нарийн болон өргөн хүрээг хамарсан нийгмийн бүлгүүдтэй хамтран ажилладаг. Бид өөрсдийн бизнесийн үйл ажиллагаа, хөгжлийн стратеги болон хөрөнгө оруулалтын төслүүддээ эрчим хүчийг үр ашигтайгаар хэрэглэх асуудлыг тусгаж өгсөн ба ингэснээр бид өөрсдийн тогтвортой хөгжлийн удирдамжийн дагуу байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллүүдийг бууруулахад хувь нэмрээ оруулна. Эрчим хүчний гол эх үүсвэрүүдийн хэрэглээг бууруулж, үр ашигтай болгоход тус болох тоног төхөөрөмж, процессуудыг чухалчилж үздэг.

Бид бүгд дор бүрнээ өөрсдийн эргэн тойрон болон ажлын хүрээнд бий болгох хог хаягдлаа зөв ангилан бууруулах, ус болон ажлын бүх хөрөнгийг зөв зарцуулах, усыг аль болох бага бохирдуулах арга хэмжээнүүдийг авч болно. Химийн бодисуудыг зөв, яюулгүй байдлаар хэрэглэснээр урьдчилан таамаглаагүй үйл явдлууд тохиолдох эрсдэлийг бууруулна.

## **ДҮРЭМ ЖУРМЫН МӨРДӨЛТ ХАРИУЦСАН АЖИЛТАН**

Дүрэм журмын мөрдөлт хариуцсан ажилтан нь компаний дүрмийг үл мөрдөх эрсдэлийг тогтмол хянах, бизнесийн үйл явцуудтай холбоотой зохих үйл ажиллагаануудыг зохион байгуулах, үр ашигтай дотоод хяналтын системийг боловсруулан хэрэгжүүлэх, бизнесийн ёс зүйг сайжруулах талаар таниулах, сургалт явуулах, зөвлөгөө өгөх, зүй бус үйлдэл, холбогдох журам, дотоод дүрэм, ёс зүйн зарчмуудыг зөрчсөн талаарх мэдээлэлд хариу өгөх, Крка дээрх компаний дүрмийн мөрдлөгийн талаар компаний удирдлагуудад тайлагнах зэрэг үүрэг хүлээнэ.

Дүрэм журмын мөрдөлт хариуцсан ажилтан нь компаний дүрмийн хэрэгжүүлэлт, энэхүү Дүрмийн заалтууд, Кркагийн зөрчлийг мэдэгдэх журмын мөрдөлтийг хянаж удирдана. Нэгж, хэлтэс, хөндлөнгийн үйлчилгээний захирлууд Дүрэм журмын мөрдөлт хариуцсан ажилтантай хамтран ажиллах ба зохих үйл ажиллагааг бий болгох, өөрсдийн эрх мэдлийн хүрээнд дүрэм журмыг мөрдсөн бизнесийн үйл ажиллагааг явуулах үүрэгтэй. Охин компани, салбаруудын захирлууд нь өөрсдийн бизнесийн үйл ажиллагаанууд нь дүрэм журмыг мөрдөж байгаа эсэхэд хариуцлага хүлээж Дүрэм журмын мөрдөлт хариуцсан ажилтанд тайлагнана. Охин компани, салбаруудын хэмжээнээс шалтгаалан тухайн компани, салбарт Дүрэм сахиулах ахлах захирлыг томилж болно.

## **ЗҮЙ БУС ҮЙЛДЛИЙГ МЭДЭГДЭХ**

“ОЧКО” Орчуулгын төвд орчуулж, хянав.  
Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот,  
Чингэлтэй Дүүрэг, Барилгачдын талбай,  
Силвер Төв, 1 тоот  
Утас/факс: 976-11-315055, 99267755

Цагийн хуваарь:  
Даваа-Баасан 09:00-19:00  
Бямба-Ням 10:00-18:00



Энэхүү Дүрмийг зөрчих нь ажлын үүргийн зөрчил болох ба сахилгын арга хэмжээ болон гэрээг цуцлах зэрэг арга хэмжээ авахад хүргэж болно. Ёс зүй болон бизнесийн дүрэм журмыг Кркагийн аль нэг түнш зөрчвөл тухайн түншийн бизнесийн хамтын ажиллагааг зогсооно.

Кркагийн ажилтнууд нь зарчим, дүрэм журмыг мөрдөхөд үргэлж анхаарал хандуулах ёстой ба ажлаа хариуцлагатайгаар гүйцэтгэх ёстой. Хэрэв таны, таны цуг ажиллагч болон гуравдагч этгээдийн үйлдэл нь энэхүү Дүрэм, хууль тогтоомж, дотоод журмын дагуу байгаа эсэх дээр эргэлзэж байвал өөрийн ахлагч эсвэл өөрийн нэгжийн захиралтай уулзан зөвлөгөө авна уу. Хэрэв нөхцөл байдал ингэх боломж олгохгүй бол Хууль зүйн Хэлтэс, Эрсдэлийн Удирдлага, Компаний дүрэм журмын мөрдлөг эсвэл Дүрэм сахиулах ахлах захирлаас зөвлөгөө авна уу.

#### Холбогдох этгээд болон утасны дугаарууд

- Дүрэм журмын мөрдөлт хариуцсан ажилтан: **+386 7 331 78 18**
- Хуулийн хэлтсийн дарга: **+386 7 331 95 95**
- Эрсдэлийн Удирдлага болон Компаний Дүрмийн Мөрдлөгийн дарга: **+386 7 331 93 93**

Энэхүү Дүрэм, Кркагийн дотоод дүрэм журмыг зөрчсөн явдал тохиолдсон гэж үзсэн аливаа этгээд энэ талаар Дүрэм журмын мөрдөлт хариуцсан ажилтанд мэдэгдэнэ. Мөн мэдэгдлийг и-мэйлээр илгээж болно ([compliance.officer@krka.biz](mailto:compliance.officer@krka.biz)).

Ажилтан бүр дүрэм журам, Кркагийн дотоод дүрэм болон энэхүү Дүрмийн дагуу бус заавар, гэрээг гүйцэтгэхээс түтгэлзэх ёстой. Бүх зөрчлийг шалгах ба бүх зөрчлийг ноцтойгоор авч үзнэ.

Крка нь мэдээлэгчийн олгосон мэдээллийн нууцлалыг хадгалж, өгсөн мэдээлэлд мэргэжлийн зохих арга хэмжээг авах ба мэдээлэгчийн эсрэг гаргаж болох хариу үйлдлээс мэдээлэгчийг хамгаална.

Мэдээллийг сайн дураар өгөх нь ёс зүйгүй, дүрэм журмыг мөрдөөгүй үйлдлийн үр дагаврыг бууруулж, арилгаж, урьдчилан сэргийлж болох тул Крка нь мэдээллийг сайн дураар өгөх явдлыг дэмжиж уриалдаг.

#### ЭЦСИЙН ЗААЛТ

Кркагийн Дүрмийг Крка, Ново местогийн Удирдлагын Зөвлөл өөрийн 2018 оны 5 сарын 15-ны хурлаар батласан бөгөөд 2018 оны 5 сарын 1-ээс хойш хүчинтэй байна.

Кркагийн дүрэм нь Кркагийн дотоод вебсайт ([Krkkanet](http://Krkkanet)) болон Кркагийн олон нийтийн вебсайт дээр тавигдсан байна.

Энэхүү Дүрэм хүчин төгөлдөр болох өдөр Кркагийн 2009 оны 12 сарын 2-ны ёс зүйн дүрмийн хүчин төгөлдөр хугацаа дуусах ба энэхүү Дүрэм нь бүрэн орлоно. Кркагийн Дүрэм нь Ёс зүйн Дүрмийн хууль ёсны залгамжлагч юм.

Ажилтан бүрд Кркагийн Дүрмийн агуулгыг танилцах семинарт танилцуулсан байна.

“ОЧКО” Орчуулгын төвд орчуулж, хянав.  
Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот,  
Чингэлтэй Дүүрэг, Барилгачдын талбай,  
Силвер Төв, 1 тоот  
Утас/факс: 976-11-315055, 99267755

Цагийн хуваарь:  
Даваа-Баасан 09:00-19:00  
Бямба-Ням 10:00-18:00





*Англи хэлнээс орчуулав.*

Кркагийн бүх ажилтнууд Кркагийн Дүрэм хүчин төгөлдөр болсоноос хойш нэг жилийн дотор Дүрэмтэй танилцсан байх ёстой.

“ОЧКО” Орчуулгын төвд орчуулж, хянав.  
Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот,  
Чингэлтэй Дүүрэг, Барилгачдын талбай,  
Силвер Төв, 1 тоот  
Утас/факс: 976-11-315055, 99267755

Цагийн хуваарь:  
Даваа-Баасан 09:00-19:00  
Бямба-Ням 10:00-18:00

